



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 27

Хараат

Төсөл сонгон шалгаруулах
хороог байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийн 35.1.17, 48 дугаар зүйлийн 48.1 Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар батлагдсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлтэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн 3.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит долоодугаар хуралдаанаас хэлэлцээд ТОГТООХ нь:

1. Хоршоог хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Хорооны дарга: 3. Солонго (Засаг даргын Тамгын газрын дарга)

Нарийн бичгийн дарга: Хорооны асуудал хариуцсан мэргэжилтэн


Гишүүд: Б.Цэндмаа (Санхүү албаны дарга)

Д.Амармэнд (Аймгийн худалдаа аж үйлдвэрийн гишүүн)

Т.Өлзийжаргал(Аймгийн худалдаа аж үйлдвэрийн гишүүн)

2. Суманд хоршоог хөгжүүлэхэд баримтлах чиглэлийг хавсралтаар баталсугай.

3. Төслийг журмын дагуу сонгон шалгаруулж, иргэдийн оролцоог хангах, гэрээний биелэлтийг хангуулах, хэрэгжилтийн явц, үр дүнг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд хагас, бутэн жилээр тайлагнахыг хорооны дарга (3. Солонго)-д даалгасугай.



“ХОРШООГ ХӨГЖҮҮЛЭХ САН”-ГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

№	Эдийн Засгийн салбар	Чиглэл
1	Хүнсний үйлдвэр	<ul style="list-style-type: none"> - Сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл - Талх нарийн боов гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэл - Малын дайвар бүтээгдэхүүн боловсруулах, худалдаалах - Хоол үйлдвэрлэл
2	Хөнгөн үйлдвэрлэл	<ul style="list-style-type: none"> - Төмөр эдлэл үйлдвэрлэл - Оёдол эсгүүрийн үйлдвэрлэл - Гутал үйлдвэрлэл - Модон эдлэл / мужаан, гэрийн тавилга/ - Сүлжмэл нэхмэл ноос ноолууран эдлэл - Хог хаягдал ангилан ялгалт, дахин боловсруулах
3	Газар тариалан	<ul style="list-style-type: none"> - Төмс, хүнсний ногоо - Мод жимс жимсгэнэ тариалах - Хүлэмжийн аж ахуй - Тэжээлийн ургамал тарилалт
4	Мао аж ахуй	<ul style="list-style-type: none"> - Арьс шир боловсруулах - Эсгий эдлэл - Малын үржлийн ажил үйлчилгээ - Мал эмнэлгийн ажил үйлчилгээ - Гахай, шувууны туслах аж ахуй
5	Барилга	<ul style="list-style-type: none"> - Блок, тоосго, замын өнгөт хавтан үйлдвэрлэл - Зөөврийн сууц, төмөр хашаа, хийц
6	Үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> - Үсчин, гоо сайхан манекюр - Авто засвар дугуй засвар - Гагнуур - Гутал засвар - Зочид буудлын үйлчилгээ - Аялал жуучлал үйлчилгээ - Барилгын засвар үйлчилгээ - Цахилгаан хэрэгслийн засвар үйлчилгээ